

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЗАРЛАСАН “ХАРИУЦЛАГЫН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ЦАГААНДЭЛГЭР
СУМАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2018.12.03

№	Албан даалгавар, Засгийн газрын тогтоолоор өгсөн үүрэг	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6
1	Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх. Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах.	1. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах талаар байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлж ажиллах.	-Байгууллага бүр дотоод журмандаа хэрэгжүүлсэн байх.	ЗДТГ-аас нийт албан хаагчидтай ёс, зүй хариуцлагын гэрээг байгуулж ЗДТГ-т 3 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн хороог байгуулж ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг тооцож ажилласан байна. Мөн бүх албан хаагчдад төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, ёс зүйн зарчмыг хэвлэн өгч өрөө бүрт болон мэдээллийн самбарт байршуулсан. ЗДТГ-ын албан хаагчид болон байгууллагын дарга нарт ЗГ-ын 2018 оны төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 258-р тогтоолтой танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Уг тогтоолд тусгасны дагуу 1.7, 1.10 дахь заалтуудыг 2018.09.10-ны өдөр албан хаагчдаараа хэлэлцүүлж дотоод журамдаа өөрчлөлт оруулж 6-р бүлгийн 6.1.2/л/, 6.5.1/с/ дэхь заалтуудыг нэмж тусган баталгаажуулсан. 	100
				ЕБС нь сургуулийн дэргэдэх “Ёс зүйн хорооны зөвлөл” байгуулсан. Ёс зүйн дүрэм журмыг боловсруулж багш, ажилчид танилцуулсан. Сургуулийн “Ёс зүйн хороо”-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба “Ёс зүйн хороо”-ны даргаар багш О.Ариунаа ажиллаж байна. Сургуулийн дотоод журамдаа ёс зүй, сахилга хариуцлага сайжруулах талаарх 4.3, 4.5 дахь заалтыг тусгаж өгсөн. Соёлын төвөөс Засгийн газрын 01 албан даалгавар, 258 дугаар тогтоолын 1.7, 1.10-д заасан заалтуудыг	

			байгууллагын дотоод журамд 9.4 дэх заалтыг нэмж оруулж шинэчлэн баталгаажуулсан. Албан хаагч нартай сахилга хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Цэцэрлэгийн зүгээс Засгийн газрын “Сахилга хариуцлага,дэг журмыг чангатгах” албан даалгаврыг байгууллагын 11 ажилтан, 45 эцэг эхчүүдэд танилцуулж, ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажилласан ба албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах талаар дотоод журмын 10.9, 10.12 дахь заалтуудыг нэмж тусган мөрдөж ажиллаж байна. ЭМТ-ийн хувьд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах талаар байгууллагын 2018 оны дотоод журамд тусган, ажилчдын цаг барилт, цаг ашиглалтыг сайжруулах зорилго тавин ажиллаж байна. Мөн ЗГ-аас хариуцлагын жил болгон зарласантай холбогдуулан дотоод журамд хөдөлмөрийн сахилгын 8.1-8.4 дахь заалтуудыг нэмж оруулсан. 2018.10.12-ний байгууллагын хурлаар нийт албан хаагчдад ажлын цагийг барьж ажиллахыг шаардаж, нярав Н.Пүрэвхүүд ажлын цагийн бүртгэлийг автоматаар бүртгэх бус шударга үнэнчээр бүртгэхийг сануулснаар ажилчдын цаг барилт, цаг ашиглалтын байдал сайжирсан үр дүн гарч байна. Мөн цаашид ажлын цагийн бүртгэл болон хурууны хээний бүртгэлээр цалинг бодож олгохыг нийт ажилтан албан хаагчдад анхааруулав.	
	2. Албан хаагчдыг чадавхжуулах байгууллагын сургалтын төлөвлөгөөг улирал тутам гаргаж, үр дүн биелэлтийг тооцож шинэ арга зүйг ажилдаа хэрэгжүүлж ажиллах.	-Сургалтуудыг чанар үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тооцсон байх. -Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх -Сургалтын үр дүнг тооцож ажилласан байх.	ЗДТГ нь төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг 2017 оны 12 сарын 21-ний өдөр Тамгын газрын даргын А/49 тоот тушаалаар баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2018 онд гарган хэрэгжүүлж хэрэгжилтийг тооцож ажилласан. 2018 оны 11-р сарын эцсийн байдлаар 90%-тай хэрэгжиж байна. 2018 онд улс аймаг, бүсийн сургалтанд 17 албан хаагч хаагч тус бүр 1-5 удаа аймгийн төвд 17, хотод 5 удаагийн сургалтад хамрагдсан байна. Сургалтад хамрагдаад ирсэн албан хаагчид долоо хоног бүрийн Лхагва гарагийн мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчдад сургалт семинарын талаарх мэдээллийг тавьж хэвшсэн.	100

				Соёлын төвөөс төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 7 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан гаргаж, жил, улирлаар гарган баталгаажуулж, үр дүнг улиралаар тооцон ажилласан. Жилийн эцсийн байдлаар эрхлэгч 7 удаа, номын санч 1 удаа, бүжгийн багш 4 удаа улс, аймаг, бүсийн сургалтад тус тус хамрагдсан байна. Сургалтын үр дүнг тухай бүр нь тайлагнуулж хэвшсэн байна. ЕБС-ийн номын санч, бичиг хэргийн ажилтан, захирал нар “Төрийн албаны сахилга хариуцлага” аймгийн нэгдсэн зөвлөгөөнд оролцож архивын анхан шатны 2 хоногийн сургалтанд суусан. “Багшийн ёс зүй” сэдэвт сургалтыг бага ангийн багш Б.Баянтунгалаг багш, ажилчдад явууллаа. Шинээр ажилд орсон ТАХ-ын 3 удаагийн сургалтыг НТБ-ын нэгжээс зохион байгуулсан. Үүнд: Ниймгийн ажилтан Г.Хандмаа, үйлчлэгч Н.Нарантуяа, А.Алтантуяа нар хамрагдсан. Ажлын хариуцлага, цаг ашиглалт, чөлөөл зөвшөөрлийн асуудлаар багш, ажилчидтай сургуулийн захирал ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгсөн. ЭМТ-өөс эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах хүрээнд сувилагч Б.Мөнхтамирыг 3 сарын Улаанбаатар хотод вакциначторын дээшлүүлэх сургалтанд хамруулсанаар ээлжийн амралттай байгаа вакциначтор сувилагч Г.Буянжаргалын ажлыг орлон гүйцэтгэж, иргэдэд ээлтэй, түргэн шуурхай хугацаанд нь тарилгаа 100% хамруулж ажиллаж байна. Дүн бүртгэгч С.Энхтөр нь Улаанбаатар хотын эрүүл мэндийн хөгжлийн төвд статистикийн 3 сарын сургалтанд 5 сараас эхлэн суралцаж төгссөн. Нийт давхардсан тоогоор 6 удаагийн сургалтанд 10 хүн хамрагдсан. Байгууллагын сургалтын сарчилсан төлөвлөгөөг улирал тутам НЭМС Г.Энхжаргал гаргаж, 7 хоногийн пүрэв гариг бүр дотоод сургалт хийгддэг. Мөн ЗТДГ-аас лхагва гариг бүр зохион явуулдаг мэдээллийн цагт ажилчид бүрэн хамрагддаг. Мөн НЭМС Г.Энхжаргал ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад лхагва гариг бүр сургалт хийж байна. 2018.06.20нд ЗДТГ-ийн мэдээллийн цагт их эмч А.Өлзийжаргал тамхины хор хөнөөлийн талаар сургалт хийсэн. Цэцэрлэгээс албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг	
--	--	--	--	---	--

				сайжруулан шинэчилэн, жилийн ажлын төлөвлөгөөнд 8 удаагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж, одоогоор 5 удаагийн сургалтыг хийж, нийт багш ажилчдын 90%-ийг хамруулсан.	
		3. МУ-ын ЗГ-ын 2017 оны 01 тоот албан даалгавар, ЗГ-ын 32 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар захирамж зэрэг тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган эрчимжүүлж ажиллах.	-Тухай бүр дүгнэж хариуцлагажуулан, зөрчил дутагдалыг бууруулж ажилласан байх.	ЗДТГ-аас ЗГ-ын 2017 оны 01 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх 16 заалт бүхий сумын төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тооцож дүгнэхэд хэрэгжилт 96,2%-тай байна. ЗГ-ын 32-р тогтоолыг хэрэгжүүлэх 36 заалт бүхий төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тооцож ажиллахад хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 90%-тай байлаа. Албан байгууллагууд сумын төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллага тус бүр дээрээ гарган хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дүгнэж ажилласан.	100
2	Авилгын хяналтыг сайжруулах. Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авилга, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх.	4. Нийтийн албанд нэр дэвшиж буй албан тушаалтнуудын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулсан дараа томилж хэвшүүлэх.	-ХАСУМ хянуулж, олон нийтэд ил тод болгосон байх.	2018 онд 3 албан тушаалтан томилогдсон. Нийтийн албанд нэр дэвшсэн 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж ашиг сонирхлын зөрчилгүй тухай дүгнэлт ирүүлсний дараа томилж энэ ажил хэвшсэн.	100
		5. Захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт, хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ хэлэлцээр байгуулах, оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчлийн талаар тайлбарыг дээд шатны албан тушаалтанд гаргах буюу хариу өгөх, хяналтыг нэмэгдүүлэх.	-Мэдээлэл, тайлбарыг үнэн зөв гаргаж шийдвэрлүүлсэн байх.	Төрийн албан хаагчдад захиргааны шийдвэр гаргах, аливаа асуудал хэлэлцэж шийдвэрлэхийн өмнө ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбарыг гаргаж ажиллах талаар мэдээлэл хийсэн. 5 мэдэгдэл тайлбар гарсан.	70

3	Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах.	6. Захиргааны ерөнхий хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр батлах, боловсруулахдаа иргэдээ сонсох, саналыг нь тусгах ажлыг зохион байгуулж хэвших.	-Сум, байгууллагын дарга нараас батлан гаргасан эрх зүйн актуудыг хянаж, хуульд нийцсэн зөрчилгүй шийдвэр гарсан байна. -Иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь хуульд нийцсэн, хууль, зүй дотоод хэргийн яамаар хянагдсан байна.	Сумын засаг даргын Б захирамж 18, А захирамж 91, Тамгын газрын даргын Б тушаал 24, А тушаал 31-ийг аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-т хянуулсан. Байна.	70
		7. Сумын Засаг даргаас Иргэдээ сонсох уулзалтыг зохион байгуулах.	-2-оос доошгүй уулзалтыг зохион байгуулан, иргэдийн санал бодлыг сонсож, хэрэгжүүлэх, арга хэмжээ авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх.	Сумын ЗДТГ-аас 4 сарын 18-нд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж ЗДТГ-ын албан хаагчид мэдээлэл хийж, иргэдийн асуултанд тухай бүр холбогдох албан хаагчид хариулт өгч ажилласан. Мөн 4 багийн нэгдсэн өдөрлөгийг 6-р сард зохион байгуулж иргэдтэй уулзалт зохион байгуулсан. Мөн 9-р сард багуудын иргэдийн нийтийн хуралд ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүд баг тус бүрийн хуралд оролцож цаг үеийн ажлаар мэдээлэл хийж иргэдийн асуултанд хариулж ажилласан.	70
		8. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан санал, хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалд дотоод хяналт хийж, дотоод хяналтын дүн мэдээг удирдлагуудад танилцуулж сурталчлах.	Баг, байгууллага бүр ӨГСХ шийдвэрлэлтийн байдалд дотоод хяналт хийж, дүн мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй сурталчилсан байх. -ӨГСХ шийдвэрлэлтийн хариуг хуулийн хугацаанд нь өгсөн байх.	ЗДТГ-т нийт 257 СӨГ ирсэн байна. Үүнээс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж үйлчилгээтэй холбоотой 85, газар эзэмших, ашиглахтай холбоотой 36, ХАА-тай холбоотой 42, шилжих 11, ажлаас чөлөөлөгдөх 8, ажилд орох өргөдөл 4, бэлчээр нутгийн маргаантай 29, мал эмнэлгийн үйлчилгээний холбоотой 25, чөлөө хүссэн 17 өргөдөл байна. ЕБС-д ирсэн ӨГСХ-ийг захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэдэг. Энэ хичээлийн жилд ажлаас чөлөөлөгдөх өргөдөл 5, ажилд орох өргөдөл 7, ёс зүйн доголдол гаргасан багшийн талаарх өргөдөл 1 ирснийг цаг тухай бүрт нь хуралдан шийдвэрлэж зохих арга хэмжээнүүдийг авдаг. Цэцэрлэгт 15 санал, хүсэлт, ажилд орохыг хүссэн өргөдөл 16, ажлаас гаргах өргөдөл 2, 2 гомдол ирсэн. Ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 45% нь ажилд орохыг хүссэн, 5% ажлаас халагдах хүсэлт, 28% барилгын асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх санал, 17% бусад асуудлаар оруулсан санал, 5% багшийн зан харилцаатай холбоотой гомдол байлаа. СӨГХ-ийг хугацаандаа шийдвэрлэж шийдвэрлэлийн хувь 88%-	100

			тай байна. Хугацаа хүлээгдэж байгаа 1 өргөдөл, ирсэн саналуудаас хэрэгжээгүй 4 санал байна. Байгууллагын ажил сайжруулах санал хүсэлтэнд зориулалтын бус барилгад үйл ажиллагааг явуулж буй тул бүлгийн өрөөг бүрэн камержуулах хүсэлт ирснийг 100% хэрэгжүүлж, эцэг эхчүүдэд танилцуулсан. 2018 онд ЭМТ-д иргэдээс ирсэн санал 1, гомдол 2, ажилд орохыг хүссэн өргөдөл 11, ажлаас халагдах өргөдөл 2, Суралцах хүсэлтэй өргөдөл 6 ирсэн байна. Дотоод хяналт, чанарын багууд хамтран санал, хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалд дотоод хяналт хийж ажилладаг. Чанарын багаас 2018 оны туршид 5 удаагийн хяналт шалгалт, халдвар хяналтын багаас 2 удаагийн хяналт шалгалт хийсэг байна. Соёлын төвд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 иргэн өргөдөл гаргасан байна. Үүнд өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх 1, ажилд орохыг хүссэн 3 иргэн өргөдөл гаргасныг хуулийн хугацаанд шийдвэрлэж санал хүсэлт, өргөдөл гомдлын дэвтэрт тухай бүр нь бүртгэн авч ажиллаж байна. Байгууллага нь улирал бүр ард иргэдээс үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, мөн цаашид хийх шинэлэг ажлын саналыг авч ажилладаг. 2018 онд нийт 3 удаа 164 иргэнээс санал асуулга авч цаашид анхаарах болон хийх ажлыг сар бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Иргэдээс ирсэн саналын 80-с дээш хувийг “шинэ барилгатай болох” гэсэн санал эзлэж байна.	
	9. Иргэдээс ирүүлсэн ӨГСХ шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүр сум, хэлтэс агентлагуудаас авч нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх.	-Тайлан мэдээг бүх сум, хэлтэс, агентлагууд улирал бүр гарган хугацаанд нь ирүүлсэн байх.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын бүртгэн авч холбогдох ажилтанд өгч шийдвэрлүүлэн хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж хэвшсэн. Төрийн байгууллага, багийн Засаг дарга нар, албан хаагчдад ирүүлсэн СӨГХ-ийг улирал тутам ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан нэгтгэн аймгийн ЗДТГ-т мэдээлдэг. Засаг даргын Тамгын газрын СӨГомдол хүлээн авах утас 89643553, ЭМТ-д 89826055 нээлттэй утаснуудыг ажиллуулж байна. Албан байгууллага, албан хаагч нарт 2018 онд иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдол, ирсэнийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хяналтын картаар хяналт тавьж, улирал бүрийн эцэст СӨГ-ийн мэдээг нэгтгэн тайланг	100

				холбогдох байгууллагад цахимаар болон цаасаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2018 оны 11 сарын эцсийн байдлаар нийт 335 санал хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, иргэдэд хариуг цаасаар болон утсаар, биеэр уулзаж хариуг өгч ажиллалаа.	
4	Төрийн албаны үр ашгийг сайжруулах. Ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа үр дүнтэй хийж, гүйцэтгэх ажлын байрны дэг журмыг чанд сахих.	10. Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод анализ дүгнэлт хийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх.	-Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод анализ, дүгнэлт хийсэн байх. -Төрийн албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн байх.	ЗДТГ нь албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах ажлын хэсгийг тушаалаар батлан ажиллуулж ажил үүргийн хуваарь, ачааллыг тэнцвэржүүлэх талаар саналаа хэлэлцэн ажлыг байрны тодорхойлолтод тусган шинэчлэн баталсан. Цэцэрлэгээс ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийж дахин боловсруулах ажлын хэсгийг эрхлэгчийн 16 тоот тушаалаар томилон ажиллуулаа. Ажлын хэсэг нь албан хаагчдад хуучин ажлын байрны тодорхойлолтыг 7 хоног судлах чиглэл өгч, багш ажилчидад ажлын байрны тодорхойлолт гэж юу вэ, хэрхэн хэрэгжүүлж, ажиллах талаар сургалтыг 09 сарын 19-нд зохион байгуулан 11 ажилтан оролцлоо. 09 дүгээр сарын 20-ны өдөр ажлын байрны тодорхойлолтын талаар хэлэлцүүлэг, дүгнэлт гаргаж харилцан ярилцаж шинээр оруулах саналуудыг тусган ажлын байрны тодорхойлолтыг шинээр зааврын дагуу боловсруулан, ажилтан нэг бүрт танилцуулан гарын үсэг зуруулж, ажлын хэсгийн ахлагч гарын үсэг зурж, эрхлэгчээр баталгаажууллаа. ЭМТ нь 2018 онд 18 ажилчдын ажлын байрны тодорхойлолтонд анализ, дүгнэлт хийж шинэчилсэн. Орлон гүйцэтгэх ажлыг илүү сайн тусгаж оруулсан. Албан хаагчдын хувийн хэргийнг шинэчлэн бүрдүүлж ажиллаж байна. Соёлын төвөөс 2018 оны 01 сары 24-ны өдөр ЗГ-ын 34 дугаар тогтоолын дагуу Соёлын төвийн 4 албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж ажил үүргийн чиг үүргийг нарийвчлан тогтоож, ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн. Томилогдсон ажлын хэсэг нь Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль зэргийг бусад албан хаагчдад танилцуулж ажиллалаа.	100

				ЕБС-аас ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийж ажлын давхардал хийдлийг тэнцвэржүүлэхэд анхаарч захиралын тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж 22 албан хаагчийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж албан хаагчдад танилцуулж баталгаажуулсан.	
		11. ЗДТГ болон бусад төсвийн байгууллагын дарга эрхлэгч нар болон албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд хагас бүтэн жилд дотоод хяналт хийж, ажлын цаг ашиглалтыг сайжруулах.	-Ажлын цаг ашиглалтын байдалд дотоод хяналтыг хийсэн байх. -Байгууллагын дарга эрхлэгч нар болон төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт дээшилсэн байх.	ЭМТ, ЗДТГ нь албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хянах, хариуцлагажуулах зорилгоор ОНХС-ийн 1600000 төгрөгийн хөрөнгөөр хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмжийг авсан. Албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд дотоод хяналтын баг сар болгон цагийн баланс гаргахын өмнө хяналт тавьж дүгнэдэг. Ажлын цагаар гадуур ажиллах шаардлага гарсан үед байгууллагын удирдлагад мэдэгдэж гадуур ажиллах дэвтэрт бүртгүүлж хэвшсэн. Засгийн газрын 2018.04-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, 2018 оны 138-р тогтоолыг үндэслэн төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах, төрийн байгууллагуудад интернетийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд /facebook, youtube, twitter/ нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай ЗДТГ-ын албан хаагчид, байгууллагын дарга нарт хуралдааны тэмдэглэл болон 138-р тогтоолыг танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилласан. 7 хоногийн хугацаатай хүн болгонд удирдлагаас үүрэг даалгавар өгдөг. Үүнийгээ 7 хоног болгон хамт олны хурлаар тайлагнадаг. Соёлын төвөөс ажлын цаг ашиглалт, бүртгэлийн явцад улирал бүр дотоод хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар ажлын цаг бүртгэхдээ автоматаар бүртгэх, ажлын цагаар Facebook, youtube орж ажлын цагийг үр бүтээлгүй өнгөрөөх зэрэг дутагдал илэрснийг арга хэмжээ авч байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, холбогдох албан хаагчид амаар сануулга өгсөн.	100
		12. Төрийн албан хаагчидтай байгуулсан	-Гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж, төрийн албан	ЗДТГ нийт албан хаагчидтай үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Үр дүнгийн болон	

		үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас бүтэн жилээр дгүнэн, ажлын үр дүнтэй уялдуулан шагнал урамшуулал, хариуцлагыг тооцож байх.	хаагчдын ажлын бүтээмж дээшилсэн байх. -Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцогдсон байх.	хөдөлмөрийн гэрээг хагас жилээр дүгнэхэд төрийн захиргааны 6 албан хаагчаас А үнэлгээтэй 1, В үнэлгээтэй 3, дүгнүүлээгүй 2 албан хаагч, төрийн үйлчилгээний 6 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг дүгнэхэд А үнэлгээтэй 3, В үнэлгээтэй 1, С үнэлгээтэй 1, D үнэлгээтэй 1 албан хаагч байлаа. С болон D үнэлгээтэй дүгнэгдсэн 2 албан хаагчид цаашид ажил сайжруулах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. ЭМТөв хөдөлмөрийн гэрээг нийт ажилчидтай байгуулж улирал тутам дүгнэж, үр дүнгийн урамшуулал олгодог. Эхний 3 улирлын үр дүнг тооцон урамшуулал олгосон. Соёлын төвийн 3 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг байгуулан хагас жилээр ажлын үзүүлэлтийг дүгнэсэн. Бүх ажилчдын голчийг харахад гүйцэтгэлийн хувь 89%-тай гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлэн ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар ажилчдын цалинг цаг тухайд нь олгож, 3 албан хаагчид тус бүр 1, 2, 3-р улиралын ур чадварын нэмэгдлийг тус бүр олгосон байна.	70
		13. Байгууллага бүр төрийн албан хаагчдаас ажлын байрны нөхцөл байдлын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааг үндэслэн ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах.	Сэтгэл ханамжийн судалгаа авсан байх. -Судалгаа болон гарсан санал хүсэлтийг үндэслэн хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн үр дүнд хүрсэн байх.	Байгууллага бүр хаагчдаас ажлын байрны нөхцөл байдлын талаар сэтгэл ханамжийн судалгаа авсан. Тухайлбал ЗДТГ-аас байгууллагынхаа өнгө үзэмж, ажиллах орчноо сайжруулах, ажилчдад тулгамдаж буй асуудлын талаар санал асуулгыг 4 сард явуулж гарсан саналын дагуу төсөвт багтаан өрөө тасалгаануудад шат дараалан засвар үйлчилгээг хийхэд 400000 төгрөг, 2 компьютер, 1 принтер авахад 4 сая төг, Ланд 100 авто машиныг засварлахад 8 сая зарцуулсан байна. ЭМТөв мөн 4 сард ЗДТГ-тай хамтран “Нээлттэй” хаалганы өдөрлөг хийж, сэтгэл ханамжийн судалгааг 64 хүнээс авахад дараах 4 санал дийлэнх хувийг эзэлсэн. Үүнд: 1.ЭМТ-ийн тусламж үйлчилгээтэй холбоотой 2.Хүүхдийн өрөөг тохижуулах 3.ЭЭС-ийн даатгалаар олгогддог эмийн нэр төрлийг сайжруулах 4. Сувилагч нарыг чадавхжуулах зэрэг санал гарсан байна. Эдгээр саналуудыг ажил хэрэг болгоход анхаарч хүүхдийн өрөөг тохижуулахад 750000 төгрөг зарцуулсан бол сувилагч нарыг чадваржуулахад анхаарч сувилагч Б.Мөнхтамирыг дархлаажуулалтын олгох, 2 сувилагч НЭМ-ийн сургалтанд хамруулж чадавхжуулсан.	100

				Соёлын төв нь албан хаагчдаас ажлын байрны нөхцөл байдлын талаар сэтгэл ханамжийн судалгааг 3 удаа авч судалгаанаас үндэслэн номын сан, орон нутаг судлах танхим 2-ыг тусгаарлан тохижуулж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж 835000 төгрөгийг зарцуулсан байна.	
		14. Засгийн газрын 2017оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжийн дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хугацаанд нь чанартай үнэн зөв гаргаж ирүүлж байх.	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацааны дагуу тайлан мэдээг ирүүлж хэвшсэн байх.	Хагас бүтэн жилээр тайлагнадаг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжийн дагуу хугацаанд нь чанартай үнэн зөв гаргаж хүргүүлсэн.	100
		15. Хугацаатай бичиг, тайлан мэдээ хоцроосон албан хаагчдад хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах.	Хугацаатай бичиг, тайлан мэдээ хоцроосон албан хаагчдад хариуцлага тооцож, төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлсэн байх.	Able программаар нийт 2831 баримт бичиг ирсэн байна. Үүнээс файлын санд-404, зар мэдээ-861, захидлаар -1514, албан бичгээр-50 ирснийг хууль журмын дагуу хугацаанд нь захирдлаар 273 албан бичгийн явуулж, Засаг дарга, Тамгын газрын даргын албан бичгээр 266 бичгийн хариуг дээд байгууллагад цаг хугацаанд нь явуулж ажиллалаа.	100
5	Бодлогын тогтвортой байдлыг хангах. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.	16. Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах.	-Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө гарсан байх. -Сургалтын үр дүнг тооцсон байх.	Байгууллага тус бүр “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан баталж, жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажилласан. Цэцэрлэгээс эрхлэгч УБ хотод 2 удаа, аймаг бүсийн сургалтанд 9 удаа, багш нар 4 удаа аймгийн төвд сургалтанд хамрагдсан. Ажлын байрны дотоод сургалтыг 6 удаа явуулж багш ажилчид 100% хамрагдсан. СӨБ-ийн багшийн ангид эчнээгээр туслах багш Б.Өлзийжаргал, сантехникийн мэргэжил олгох сургалтанд жижүүр Э.Дорждавгыг хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болгож суралцах хугацааны цалинг 50-иар олгож дэмжиж ажиллалаа. ЕБС, СӨБ-ийн багш нар боловсролын чиглэлээр зохион байгуулсан бүх төрлийн сургалт семинарт 100% хамрагдсан. ЭМТ-ийн эмч, албан хаагчид болон ЗДТГ-ын албан хаагчид аймаг, орон нутгаас зохион явуулсан улс аймаг, бүсийн орон нутгийн дотоодын сургалтуудад хөтөлбөр, удирдамжийн дагуу хамрагдсан. Тухайлбал ЗДТГ-аас 1 мэргэжилтнийг ХААИС-д эчнээгээр, ЭМТ-өөс 1 сувилагчийг	100

				вакцинатор сувилагчийн 3 сарын курст, 1 сувилагчийг Дорноговь аймаг дахь АШУИС-д лаборантаар, дүн бүртгэгчийг Улаанбаатар хотод архив, бичиг хэргийн 1 сарын сургалтанд соёлын төвөөс 1 ажилтныг СУИС-ийн соёлын сургуульд номын санчийн эчнээ ангид 1 ажилтныг нийгмийн ажилтнаар суралцуулж мэргэшүүлэх тал дээр төрийн албан хаагчдыг дэмжин ажиллаж байна. Улаанбаатар хотод 3 удаагийн, аймгийн төвд болсон 15 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 28 албан хаагч хамрагдсан байна. Сумын эрх зүйн хөтөч багаас 2018 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 21 хууль тогтоомжийг судлуулахаар төлөвлөсөн. Үүнээс 11 сарын эцсийн байдлаар 14 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 208, төлөвлөгөөнөөс гадна 9 удаагийн мэдээлэл сургалтанд давхардсан тоогоор 216 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан.	
		17. Дутагдалтай боловсон хүчний судалгааг гарган, мэргэжлийн боловсон хүчнээр нөхөх арга хэмжээ авсан байх.	-Судалгааг сум, агентлаг бүр, байгууллага бүр гаргаж, тайлан мэдээг 6 сарын 20, 12 сарын 05-ны дотор аймгийн ЗДТГ-т ирүүлсэн байх.	Тус сумын 2018 оны дутагдалтай боловсон хүчний судалгааг гаргасан. ЗДТГ-т газрын даамал, байгаль орчны байцаагч, төрийн сангийн мэргэжилтэн, соёлын төвд хөгжмийн багш, ЕБС-д дуу хөгжмийн багш, ЭМТ-д 1 сувилагчийн дутагдал байна. ЗДТГ-т дутагдалтай байгаа 3 орон тоог нөхөх арга хэмжээ авч аймгийн ТАСЗ-д захиалга хүргүүлсэн. Соёлын төвд хөгжмийн багш авах зарыг олон нийтийн сүлжээнд тавьж ажилласан. Сургуульд 3 бага ангийн багш, цэцэрлэгт 2 орон тоо, ЭМТ-д 1 их эмч дутагдалтай байсныг нөхөх арга хэмжээ авч ажилласан байна.	100
		18. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг байгууллага бүр хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах.	Албан хаагчдыг ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авсан байх. Нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авсан байх.	УИХ, ЗГ-аас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөж ажиллаж байна. Оны эхэнд байгууллагын орон тоо, цалинг сар баталсан. ЗГ-ын 2018 оны 264-р тогтоол гарсантай холбогдуулан албан хаагчдын цалинг тогтоолын дагуу шинэчлэн баталж холбогдох нэмэгдэл хөлсийг олголоо. Байгууллагын дотоод журмыг үндэслэн 1-р улиралд Тамгын газрын албан хаагчдын 2018 оны ээлжийн амралтын хуваарийг гарган бүх албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлсэн. Ажилтан албан хаагчдын ажлын цагийг бүртгэн цахим бүртгэл болон бүртгэлийн дэвтрийг үндэслэн цагийн баланс гарган цалинг бодож сар бүр тогтоосон хугацаанд олгосон. Албан хаагчдад	100

			чөлөөний хуудсаар чөлөө олгож ажилласан. Албан хаагчдын амьдрах нөхцлийн сайжруулахад анхаарч багш нарын орон сууцанд 2 байрыг нийтийн халаалтанд холбож 2 сая төгрөгийг зарцуулсан. Шинээр гэр барьсан 2 албан хаагчид 310000 төг, 4 албан хаагчийн шинэ төрсөн 4 хүүхдэд 400000 төг, ар гэрийн гачигдал гарсан 7 албан хаагчид 460000 төг, 2 албан хаагчид УБ хотод эмчилгээ оношилгоонд явахад 3 албан хаагчид 135000 төг, 3 албан хаагчийг эмнэлэгт хэвтэхэд 90000 төгрөгийг тэтгэмж тусламж үзүүлсэн байна. Компьютерийн техник хэрэгслийн ашиглалтанд хяналт тавин компьютер техник хэрэгсэл, интернэтийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Энэ онд Тамгын газрын үйл ажиллагаанд нийт 20 компьютер, 15 принтер ашиглагдаж байна. Техник хэрэгслийг шинэчлэх засварлахад ЗДТГ-аас 4 сая төгрөг, Соёлын төв 1400000 төг, цэцэрлэг гарган шийдвэрлэлээ. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжид 2 багшид 6948000 төгрөг олгосон байна.	
	19. Төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь чадваржуулах хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны хуваарь баталж, тогтмол зохион байгуулж хэвших.	-“Шинэ тутам хууль тогтоомжоор төрийн албан хаагчдад эрх зүйн сургалт сурталчилгаа зохион байгуулах хуваарь гарган зохион байгуулж, мэдлэг мэдээллээр хангасан байх.	Сумын эрх зүйн хөтөч багаас 2018 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 21 хууль тогтоомжийг судлуулахаар төлөвлөсөн. Үүнээс 11 сарын эцсийн байдлаар 14 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 208, төлөвлөгөөнөөс гадна 9 удаагийн мэдээлэл сургалтанд давхардсан тоогоор 216 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан. НТБ-ын багш Н.Оюунцэцэг сургууль дээр шинээр ажилд орсон ТАХ-ыг чадавхижуулах 3 удаагийн шаталсан сургалтанд 10 төрийн албан хаагч хамрагдаж хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн хууль, аюулгүй байдал, ажлын байрны нөхцөл боломжийн талаарх сургалтанд хамрагдсан. Сургуулийн НТБ-ийн нэгжээс зохион байгуулсан англи хэлний анхан шатны 16 цагийн сургалтанд 9 төрийн албан хаагч хамрагдаж сертификат олгосон. ЭМТ, ЗДТГ-т ажилчдыг ажлын байран дээр нь чадваржуулах талаар ажлын байрны дасгал тогтмол явуулдаг. Цэцэрлэг ажлын байрандаа байгууллагын харилцаа, ёс зүй, ня-бо Б.Цэндмаа цалин, хөлс, ээлжийн амралт тооцох аргачлал, ХАБЭА-н талаар,	100

				санхүүгийн боловсрол олгох зэрэг 6 сургалт зохион байгуулж албан хаагчид бүрэн хамрагдсан. Соёлын төвөөс 14 удаагийн сургалтыг зохион байгуулж албан хаагчдаа хамруулсан.	
6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах.	20. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг ханган ажиллах.	Иргэдийг мэдээллээр хангасан байх.	2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ЗДТГ-ын мэдээллийн самбарт ил тод байршуулсан. 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилд хяналт тавихад анхаарч зохион байгуулах болон хяналт тавих ажлын хэсгийг томилон ажиллуулсан. Мөн хүнсний эрхийн бичиг, сургууль цэцэрлэгийн хоол хүнсний худалдан авалт зэргийг сумын цахим хаяг болон цаасан зараар нээлттэй зарлаж ирсэн материалыг зөвлөлөөр хэлэлцэж шийдэрлэж байна.	70
		21. Тусгай зөвшөөрлийн асуудлыг хуулийн хүрээнд зохион байгуулах, иргэд нийтэд энэ талаар мэдээлж ажиллах.	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудалд маргаан гараагүй байх.	Тус энэ онд тусгай зөвшөөрөл болон лиценз олгогдоогүй болно.	100
		22. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд ил тод, нээлттэй мэдээллэх.	Сумын ГЗБТ-г олон нийтэд нээлттэй ил тод мэдээллэсэн байх.	2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг нийтэд цахимаар болон самбараар хүмүүст хүргэж ил тод тавьсан. 63 иргэнд газар эзэмшүүлэх захирамж гаргасан.	100
		23. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох шийдвэр гаргахын өмнө ашиг сонирхолын зөрчлийн талаар мэдэгдэл, тайлбарыг тухай бүр үнэн зөв гаргаж хэвших.	Мэдэгдэл, тайлбарыг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв гаргасан байх.	Төрийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажлын хүрээнд сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг хүлээж авах, гэрээ байгуулахын өмнө албан хаагчдаар мэдэгдэл тайлбар гаргуулж ажилласан. 5 албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүссэн болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл тайлбар ирүүлснийг цаасаар бүртгэж авсан.	70
7	Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлыг	24. Нээлттэй хаалганы өдрийг улирал бүр зохион байгуулан иргэдэд ажлаа тайлагнан ажлаа	-Нээлттэй хаалганы өдрийг 4-өөс доошгүй удаа зохион байгуулсан байх. -Иргэдэд ажлаа тайлагнан сэтгэл ханамжийн судалгаа	2018 оны 4 сард ЗДТГ, ЭМТ-тэй хамтран нээлттэй хаалганы өдөр, 12 сард Соёлын төв нээлттэй хаалганы өдөрлөгийг тус тус зохион байгуулсан. Өдөрлөгт төрийн албан хаагчдаас гадна 68 иргэд оролцож цаг үеийн байдлаар мэдээлэл хийж, эрүүл	70

	хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ чирэгдэл, хүнд суртал, ёс зүйн доголдол гаргахгүй байх.	иргэдээр үнэлүүлэх.	авч дүгнэлт хийж ажилласан байх. -Иргэдийн сэтгэл ханамж урьд оноос өссөн байх.	мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж, илрүүлэг шинжилгээнд 23% хамрагдсан.	
8	Төсвийн хөрөнгө ажлын чанар, үр дүнг дээшлүүлж үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллах.	25. ЗДТГ, төсөвт байгууллага, болон санхүүгийн алба санхүүгийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах	-Сахилга хариуцлагатай ажиллах -Гарсан зөрчлийг арилгуулж зөрчилгүй ажиллуулах.	Сумын төсөвт байгууллагууд 2017 оны төрийн аудитын газар, аймгийн ЗДТГ-ын дотоод хяналт шалгалтын өгсөн зөвлөмжийн дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах, өр авлага бууруулах тал дээр Санхүү алба болон байгууллагын дарга, холбогдох албан хаагч нартай хамтран төсвийг зүй зохистой зарцуулах төсөвт байгууллага болон төсөл сангийн өр авлагыг бууруулах ажлын төлөвлөгөөг гарган 6-р сарын 20-нд хэрэгжилтийг гарган тайланг байгууллагын дарга нарын хуралд танилцуулсан. Сар бүр орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилтийн хуваарийг батлагдсан төсвийн хуваарь, маягтийн дагуу хөтөлж зарцуулалтын эрхийг байгууллага тус бүрээр нээж зориулалтын дагуу төсвийн эрх захирагчдын тушаал шийдвэрийн дагуу захиран зарцуулж байна. Аудитаар илэрсэн зөрчлийг заасан хугацаанд хэрэгжилтийг гарган алдаа зөрчлөө залруулан ажилласан.	100
		26. Хариуцлагын жилийн хүрээнд бүх байгууллагууд 2018 оны санхүүгийн тайлангаар Зөрчилгүй санал дүгнэлт авах	-Зөрчилгүй санал дүгнэлт авах	2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2018 оны 03 сарын 03-17 хооронд аудитаар оруулж баталгаажуулан дүгнэлт гаргуулсан. Аймгийн төрийн санд аудитлагдсан тайланг хүлээлгэн өгч санхүүжилтийн тооцоо нийлсэн. Сумын хэмжээнд нийт 6 төсөвт байгууллага СХС, ОНХСан бусад төсөл сангууд хамрагдсан. Төрийн аудитын байгууллагаас нийт 24,258,525 төгрөгний зөвлөмж 44,475,922.20 төгрөгний хариуцлага тооцох санал 23,550,700 төгрөгний албан шаардлага 4,000,000 төгрөгний залруулга хийгдэж сумын нэгтгэлийн дүнгээр залруулагдаагүй 47,8 сая төгрөгний зөрчил илэрч “Хязгаарлалтай” санал дүгнэлт өгсөн. Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу нэгтгэсэн тайлангийн дүгнэлтийг байгууллагын дарга нарын хуралд танилцуулан Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж цаашид авах арга хэмжээний талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Дүгнэлтийг мэдээллийн самбар	70

		27. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах үүднээс бүх шатны төсвийн захирагч, санхүүгийн албаны дарга, мэргэжилтнүүдэд санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, НББ-ын сургалтыг зохион байгуулна.	-Бүх шатны төсвийн захирагч, санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нарт санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, НББ-ын сургалт зохион байгуулсан байх. -Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх.	болон Шилэн дансанд байршуулсан. Хугацаатай зөвлөмжийн хариуг 100% өгсөн. 2018 оны 05-р сард ЗДТГ, Эрүүл мэндийн төвийн хамтарсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт оролцон 1-4 сарын санхүүгийн ажлын тайланг танилцуулсан. Мөн 06 сарын 13-нд албан байгууллагын мэдээллийн цагаар “Төсвийн тухай хууль”, “2017-2018 оны төсөв, төсвийн чиг хандлага, өнөөгийн байдал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн нягтлан бодогч Б.Цэндмаа 2-р улиралд төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой мэдээллийг байгууллагын дарга, нягтлан, нярав болон бусад холбогдох албан хаагчидад сургалт хийсэн.	 	100
9	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд	28. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган хэрэгжилтийг аймгийн ТЗУХ, ХШҮДАХ-т хагас	Хэрэгжилтийг хугацаанд нь үнэн зөв чанартай гаргаж хүргүүлсэн байх	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр харъяа төсөвт байгууллагууд, мэргэжилтнүүдээс гарган авч нэгтгэн тооцож аймгийн ХШҮДАХ-т хүргүүлсэн.	100	

	хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах.	бүтэн жилээр хугацаанд нь хүргүүлэх.			
		29. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөнөөс суманд хамааралтай заалтуудыг хэрэгжилтийг гарган аймгийн ТЗУХ, ХШҮДАХ-т хагас бүтэн жилээр хугацаанд нь хугацаанд нь хүргүүлэх.	-Суманд хамааралтай заалтуудын хэрэгжилтийг хугацаанд нь үнэн зөв чанартай гаргаж хүргүүлсэн байх	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр харъяа төсөвт байгууллагууд, мэргэжилтнүүдээс гарган авч нэгтгэн тооцож аймгийн ХШҮДАХ-т хүргүүлсэн.	100
		30. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган хэрэгжилтийг аймгийн ТЗУХ, ХШҮДАХ-т хагас бүтэн жилээр хугацаанд нь хугацаанд нь хүргүүлэх.	- Хэрэгжилтийг хугацаанд нь үнэн зөв чанартай гаргаж хүргүүлсэн байх	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр харъяа төсөвт байгууллагууд, мэргэжилтнүүдээс гарган авч нэгтгэн тооцож аймгийн ХШҮДАХ-т хүргүүлсэн. тухайлбал эрүүл мэндийн чиглэлийн 13 заалт, боловсролын хүрээний 18 заалт, соёл урлаг, биеийн тамир, спортын хүрээний 23, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын 18, хөдөө аж ахуйн 10, жижиг дунд үйлдвэрийн 4, байгаль орчны 9, дэд бүтцийн 22, төсөв санхүү 7, хууль эрх зүйн 11, төрийн захиргааны хүрээний 24 арга хэмжээний хэрэгжилтийг хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлсэн байна.	100
		31. Сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөнөөс суманд хамааралтай заалтуудыг хэрэгжилтийг гарган аймгийн ТЗУХ, ХШҮДАХ-т хагас бүтэн жилээр хугацаанд нь хугацаанд нь хүргүүлэх.	-Суманд хамааралтай заалтуудын хэрэгжилтийг хугацаанд нь үнэн зөв чанартай гаргаж хүргүүлсэн байх	Сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр харъяа төсөвт байгууллагууд, мэргэжилтнүүдээс гарган авч нэгтгэн тооцож аймгийн ХШҮДАХ-т хүргүүлсэн. тухайлбал эрүүл мэндийн чиглэлийн 14 заалт, боловсролын хүрээний 15 заалт, соёл урлаг, биеийн тамир, спортын хүрээний 18, хөдөлмөр халамжийн 9, нийгмийн даатгал 4, ХАА 9, жижиг дунд 4, байгаль орчин 7, дэд бүтцийн 12, төсөв санхүү 8, хууль эрх зүй 16, төрийн захиргааны хүрээний 16 арга хэмжээний хэрэгжилтийг хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлсэн байна.	100
10	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж бүр компанийн засаглалыг хэрэгжүүлэн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг төр, хувийн	32. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.	Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажиллах.	Тус сум нь 2016 оноос канад улсын хөрөнгө оруулалттай "Инвэст ко-оп монгол" төсөлтэй хамтран ажиллаж малчид иргэдэд чиглэсэн 9 удаагийн арга хэмжээг зохион байгуулж түүнд төслийн зүгээс 14,5 сая төгрөгийг зарцуулаад байна. Мөн америкийн хөрөнгө оруулалттай "МАННА ХӨГЖИЛ" төрийн бус	100

	хэвшлийн түншлэлийн хүрээнд шинэ шатанд гарган ажиллах арга хэмжээ авах.			байгууллагын хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгний хөрөнгөөр сумын төвд гүний худаг гаргуулаад байна. Сумын бөхийн холбоотой хамтран аймгийн зүүн бүсийн үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээнийг 9 сард, ахмадын хороотой хамтран УБ хотын БЗД-ийн 10-р хорооны ахмадын хороотой шифийн харилцаа тогтоож 2 ахмадын хорооны ахмадуудыг хамруулсан ахмадын баярын үйл ажиллагааг 9 сард, эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Бид хөршөөрөө” уралдаан, Бүсгүйчүүд дуулж байна” уралдаан, гар бөмбөгийн тэмцээнийг 3 сард, шагайн холбоотой хамтран шагайн харвааны хувийн цуваа тэмцээнийг 10 сард, уяачдын холбоо хамтран сумын наадам, уулын тахилага наадмууд, морьтны жагсаал зэрэг үйл ажиллагаануудыг хамтран зохион байгуулж ажилласан байна.	
		33. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, газар эзэмших, гэрээ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилтийг дүгнэн, хяналт шалгалтыг чанартай зохион байгуулж, хариуцлага тооцон ажиллах.	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлсэн байх.	Суманд хайгуулын зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй Сүмбэр-Орд ХХК-тай компанитай хог хаягдлын гэрээ байгуулж байгал орчинд ээлтэй байх талаас нь хяналт тавьж ажиллаж байна. Мөн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Цантын хаяа, Каймекс, Гоби грийн энерги зэрэг компаниудад нийгмийн хариуцлагаа дээшлүүлж сум орон нутагтай хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлж ажилласан. Үүний үр дүнд Сүмбэр Орд ХХК-аас 4 сая төгрөгийн хандив тусламж үзүүлж сумын өвс тэжээлийн агуулах барьж ашиглалтанд оруулсан байна.	70
11	Иргэн бүр хууль тогтоомжийг судлан мөрдөж, хувь иргэний эрх, үүргийн нийтийн эрх ашиг, үндэсний язгуур ашиг сонирхолтой зөв хослуулах замаар байгаль орчноо хайрлан	34. Засгийн газрын зарласан хариуцлагын жилийн хүрээнд хийх ажил, сахилга хариуцлагыг сайжруулах талаар хийж байгаа ажлын туршлага арга барилаа иргэдэд	-Цахим хэрэгслээр сурталчилсан байх. -Аймаг, сум, байгууллагын цахим сайтаар сурталчилсан байх.	Төрийн алба, төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж хариуцлагажуулах талаар гарсан ЗГ-ын 2017 оны 01 тоот албан даалгавах, 2018 оны 32-р тогтоол, 258-р тогтоолуудыг төрийн албан хаагч бүр уншиж судлан хэрэгжүүлж ажилласнаар төрийн албан хаагчдын дунд ажлын цаг баримтлах, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, ажлын цагаар архи согтууруулах ундаа хэрэглэх явдал гарахгүй болж үр дүнд хүрсэн. Ажлын цагийг хурууны хээгээр бүртгэж цаасан бүртгэлтэй тулгаж цалин хөлсийг олгож байна. байгууллагуудын дотоод журамд төрийн албан хаагчийн сахилга хариуцлагын талаар	70

	хамгаалах болон эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод хувь нэмэр оруулж ажиллах.	сурталчлан таниулах.		заалт нэмж тусгасан. Төрийн байгууллагууд зохион байгуулсан ажил, арга хэмжээний тухай мэдээллээ Цагаандэлгэрийн мэдээ групп болон Дундговь аймгийн нэгдсэн сайтад байршуулж ажлаа бусаддаа мэдээлж сурталчилж ажилласан.	
		35. Аймаг, сумын хэмжээнд зохион байгуулагдсан томоохон ажил арга хэмжээнд иргэд олон нийтийг идэвхтэй оролцуулж, дэмжин хамтран ажилласан байх.	Баг бүр 2-оос доошгүй арга хэмжээг дэмжиж хамтран ажиллаж иргэдээ оролцуулсан байх.	3 сард “Таван эрдэнэ-2” малчдын зөвлөгөөнийг нийт малчдын дунд явуулсан. 4 сард “Авъяаслаг боржигончуу”-д ардын урлагын наадам, 5 сард “Инээж буй хүүхэд” хүүхдийн анхдугаар чуулан, “зүүн бүсийн эмч сувилагчдын чуулган”, 6 сард 4 багийн нэгдсэн өдөрлөг, 6 сард аймгийн төвд “Дуулах өв соёл” ардын урлагын наадам, 8 сард “Нүүдэлчин Монгол-2018” соёлын биет бус өвийн уралдаан, 9 сард “зүүн бүсийн үндэсний бөхийн барилдаан”, 10 сард “иргэдийн спортын наадам”, “Залуу малчдын зөвлөгөөн”, “Төрийн албан хаагчдын зөвлөгөөн”, Говь-Угтаал суманд зохион байгуулагдсан хүндэт багш Гэндэн-яринпилийн Эрдэнэ-Очирын 70 насны ойд зориулсан “Багш Дор Мөргөмү” эрдэм шинжилгээний хурал, Г.Эрдэнэ-Очирын нэрэмжит “Монгол хэл, бичгийн олимпиад, зүүн бүсийн хүүхдийн 2-р чуулган, 11 сард “Нутаг усаараа бахархaya” явган аялал зэрэг томоохон арга хэмжээнүүдийг төрийн байгууллагууд хамтран зохион байгуулж иргэд олон нийт идэвхтэй оролцсон.	100
12	2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах.	36. 2018 оны улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх ажлын тендер, гэрээ, гүйцэтгэлт хяналт тавих, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах.	-2018 онд улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх ажлын тендерийг зохион байгуулах. -Гэрээ байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлэн ажилласан байна.	Сумын 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 13 төсөл, арга хэмжээг зохион байгуулж явуулахаар төлөвлөсөн. Үүнээс 9 төсөл, арга хэмжээг зохион байгуулсан байна.	70
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ					90%

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР